

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.27. №63 (63)

ҮЙЛ ЯВДАЛ

ТЭРГҮҮНИЙ РОТ /БАТАРЕЙ/, САЛААНЫ ЗАХИРАГЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨН ӨНӨӨДӨР ЭХЭЛЖ БАЙНА



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын рот /батареи/, салааны захирагч нарын зөвлөгөөн өнөөдөр эхэлж байна. Тус зөвлөгөөнд зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудаас шалгарсан тэргүүний рот /батареи/, салааны захирагч нар нэгдсэн зөвлөгөөнд оролцож байгаа бөгөөд онолын болон дадлага, үзүүлэх сургууль, цэргийн албаны баримт бичиг бүрдүүлэлт гэсэн хэлбэрүүдээр Зэвсэгт хүчний

хэд хэдэн ангиудын материаллаг баазыг түшиглэн явагдана. Тухайлбал, “Удирдлагын манлайлал”, “Холбоо мэдээллийн дэвшилтэт технологид суурилсан цэргийн сургалт”, “Зөв хандлага, зөв төлөвшил”, “Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөлт, зохион байгуулалт”, “Зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлого, хөгжлийн чиг хандлага”, “Буудлагын дасгал боловсруулах аргачлал үзүүлэх сургууль” зэрэг олон лекц, дадлага, үзүүлэх сургуулиуд багтжээ. Мөн энэ хүрээнд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг нар тодорхой асуудлуудаар үүрэг, чиглэл өгнө.

Зөвлөгөөн нь Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн салаа, салбарын офицеруудын биеэр үлгэрлэх, бусдыг чиглүүлэх, үүссэн хүндрэл бэрхшээлийг тодорхойлон түүнийг даван гарах, захирагдагсдаа зоригжуулах, тэднийг нэгтгэн удирдах арга барил, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Сонирхуулахад тус зөвлөгөөн хамгийн сүүлд 2003 онд зохион байгуулагдаж байсан ажээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
11	2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	22

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
31	16

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.438.00	3.544.00
CNY	443.00	447.90
RUB	38.00	40.20
JPY	25.71	26.60
KRW	2.43	2.61

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 16
2021.05.27.
/ПҮРЭВ ГАРАГ/

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН
МОГОЙ САРЫН ТАВАН ШАР
ХӨХӨГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин ирнэ.

Наран ургах, шингэх:

05.01-20.38

Барилдлага:

Үл тохирох

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

Суудал:

Огторгуй

Аргын тооллын 5 сарын 27, Бархасвадь гараг. Билгийн тооллын 16, Эрхтний тэнгэрт одтой, хөхөгчин гахай өдөр. Өдрийн наран 5 цаг 01 миутаг мандан, 20 цаг 38 минутад жаргана. Тухайн өдөр туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адуус номхруулах, нялхсын хурим хийх, сүм дуганыг сэргээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, гөлөг тэжээх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одоосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КЫЗЫЛ ХОТОД ХОЁР УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАМТАРСАН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ БОЛЛО



ОХУ-ын Батлан хамгаалах яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Олон улсын цэргийн наадам-2021” цогцолбор тэмцээний хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчин энэ жил “Аравт-2021” олон улсын морин цэргийн уралдааныг өөрийн нутагт, “Цэргийн ралли” цэргийн авто машины уралдааныг ОХУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран зохион байгуулах билээ. Үүнтэй холбоотойгоор Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан төлөвлөлтийн хурал ОХУ-ын Тува улсын нийслэл Кызыл хотод тавдугаар сарын 22-25-ны өдрүүдэд боллоо. Монгол Улсын Зэвсэгт хүчний ажлыг хэсгийн ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, ОХУ-ын талаас ОХУ-ын БХЯ-ны Авто-хуягт танкийн ерөнхий газрын

дарга, хурандаа А.Власенко, ОХУ-ын Хуурай замын цэргийн командлалын Байлдааны бэлтгэлийн газрын ахлах офицер, хурандаа А.Покровский нар ахлан оролцлоо. Төлөвлөлтийн хурал 2 үе шаттай явагдсан ба нэгдүгээр шатанд “Цэргийн ралли” авто машины уралдааныг Монгол Улстай хамтран зохион байгуулах асуудлаар, хоёрдугаар шатанд “Аравт” морин цэргийн олон улсын уралдааны зохион байгуулалтын талаар хэлэлцэж, нэгдсэн ойлголтот хүрсэн юм. Түүнчлэн Монгол Улсын Зэвсэгт хүчний ажлын хэсгийн бүрэлдэхүүн “Аравт-2021”, “Цэргийн ралли-2021” уралдаанд оролцох ОХУ-ын багийг сонгон шалгаруулах тэмцээний нээлтийн арга хэмжээнд оролцож, тэмцээний явцтай танилцсан юм.

НИСЭХ ХҮЧНИЙ 96 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЛОО



Зэвсэгт хүчний 303, 337 дугаар анги Монгол Улсад нисэх хүчин үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлээ. Ойн арга хэмжээний хүрээнд тус хоёр ангиас цэргийн тэтгэвэрт гарсан ахмадууд байлдааны тугандаа хүндэтгэл үзүүлж, төрийн дээд одон, медалиар шагнууллаа.

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагч, хурандаа Г.Бат-Орших “Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойгоор манай анги Цэргийн гавьяаны одонгоор шагнагдсан. Мөн өнгөрсөн жил ангийн түүхт 50 жилийн ой тохиосон. Манай ангийн түүх 1970 оноос эхэлдэг бөгөөд анх удаа орчин цагийн тийрэлтэт хөдөлгүүртэй сөнөөгч-бөмбөгдөгч онгоцны хороо бий болж Монгол Улсын нисэх хүчний түүхийн шаргал хуудсыг арвижуулж ирсэн юм” гэв.

Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн

захирагч, дэд хурандаа Д.Шатаррагчаа “1925 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Монголд “Ю-13” онгоц бууснаар нисэх хүчний түүх эхэлсэн. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн бүрэлдэхүүн Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдалд хяналт тавих, онцгой болон тусгай үүргийн нислэг үйлдэх, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлж орчин үеийн сургууль байлдааны сөнөөгч онгоц, нисдэг тэрэгнүүдийг чадварлаг эзэмшиж үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгааг онцлон хэлэхэд таатай байна. Цэргийн нисэхийн нийт бие бүрэлдэхүүнд Зэвсэгт хүчний түүхт 100 жил, Монгол Улсад нисэх хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 96 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүл” гэв.

Мөн тус арга хэмжээний үеэр уг хоёр анги үе үеийн захирагч нар, нисгэгч, техникч, механикч нараа хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

53.691

ЭДГЭРСЭН

48.041

НАС БАРСАН

257/2

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2421 (34)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

219

ЭДГЭРСЭН

2166

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 169,057,099

Эдгэрсэн

Нийт: 150,693,341

Нас барсан

Нийт: 3,511,532

“ЭРҮҮЛ МЭНДИЙНХЭЭ ТӨЛӨӨ - ААХАНГАА ЯРЦАЦЬЯ”

ДАРХЛААГ ДЭМЖИХ ЦАХИМ АЛЖАЛТЫН 7 ХОНОГ

2021 оны 05 дугаар сарын 24-30 өдөр

ҮЙЛ ЯВДАЛ

ХОШУУЧ ГЕНЕРАЛ Б.АМГАЛАНБААТАР ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААНЫ ТУГИЙН ОДОН ХҮРТЛЭЭ



Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон хүртээснийг өнгөрсөн мягар гаратг ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг гардуулан өгч, баяр хүргэлээ.

Хошууч генерал Д.Ганзориг Хуурай замын цэргийн командлал нь хууль тогтоомжийн хүрээнд бие даан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш цэргийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэн хэвшиж, өдгөө үйл ажиллагаа нь жигдэрсэн, бусад төрлийн цэргийн командлалдаа үлгэрлэл үзүүлэх олон бүтээлч ажил өрнүүлсэн гэдгийг шагнал гардуулах үеэр онцлон

илэрхийлж байсан юм. Хошууч генерал Б.Амгаланбаатар нь 1982-1986 онд Цэргийн нэгдсэн дээд сургуулийг Ерөнхий цэргийн команд-Явган цэргийн байлдааны машины ашиглалтын инженер мэргэжлээр суралцаж төгсөөд, Ардын Армийн 150 дугаар ангиас салааны захирагчаар ажлын гараагаа эхэлсэн цэргийн дээд офицер юм.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБАНЫХАН ЦАХИМ ХУРАЛ ХИЙЛЭЭ

Зэвсэгт хүчний Жанжин штабын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга, хурандаа Ж.Хоролсүрэн тэргүүтэй тус албаныхан өнгөрсөн мягар гаратг Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын нууц хадгалалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан албан тушаалтнуудтай цахимаар хуралдлаа. Хурлаар

мэдээллийн аюулгүй байдлыг хангахад анхаарах, сошиал орчинд албаны нууцыг дэлгэсэн гэрэл зураг, бусад мэдээллийг оруулахгүй байх, Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа эхэлсэнтэй холбогдуулан цэргийн алба хаагчид аль нэг нам, нэр дэвшигчийг дэмжсэн улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх зэрэг олон чухал асуудлаар

мэдээлэл өгч, харилцан санал солилцлоо.

Мөн нууц хадгалалт, хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдал хариуцсан албан тушаалтнуудад Зэвсэгт хүчний нэр хүндийг өндөрт өргөх эрхэм үүргээ ухамсарлаж, цэргийн алба, сахилга хариуцлагаа дээшлүүлж, ажил албаа долоо хоног бүрээр төлөвлөж, хэрэгжилтийг нь хангахад анхаарахыг захилаа.



ЦАХИМ ШУУДАНД

ШАГНАЛЫН ХУР БУУСАН ӨДӨР

Зэвсэгт хүчний 013 дугаар анги



Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан Төрийн одон, медаль, Батлан хамгаалах салбарын болон Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медаль, тэмдгээр шагнагдсан офицер,

ахлагч, ажилтан албан хаагчид, ахмад дайчдын шагналыг гардуулах арга хэмжээг ангийн тайлангийн хурлын үеэр зохион байгууллаа. Арга хэмжээнд ангийн удирдлага, ахмад дайчдын төлөөлөл, бие бүрэлдэхүүн хамрагдлаа. Мөн өдөр цэргийн тангараг

давтаж, цэргийн гавьяаны амралт, тэтгэвэр чөлөөнд гарсан цэргийн алба хаагчдыг ангийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, дурсгалын зүйл гардуулах үйл ажиллагааг ангийн захирагчийн зөвлөл, ахлагчийн зөвлөлөөс зохион байгуулж явууллаа.

Хошууч С.БАТБААТАР

"БОСОО ХИЙМОРЬ" НОМЫН НЭЭЛТ БОЛЛОО



"Монгол хурандаа" нийгэмлэгийн тэргүүн, УАБЗ-ийн шинжээч, Монгол Улсын Гавьяат багш, доктор, профессор,

Ч.Баатарын "Босоо хийморь" номын нээлтийн үйл ажиллагаа энэ сарын 25-нд "Интерном" номын дэлгүүрт боллоо. 1990-ээд оны үеийн зах

зээлийн нийгэм дэх тухайн үеийн залуучуудын амьдралын төлөөх тэмцлийн талаар өгүүлсэн "Босоо хийморь" зохиол нь түүний бичсэн 18 дахь бүтээл бөгөөд анхных нь бүрэн хэмжээний роман юм. Тус роман нь залуу хүн ямар ч цаг үед эх орноо гэсэн сэтгэлтэй, үргэлж алсыг харж, өмнөө том зорилго тавьдаг байх нь чухал гэсэн санааг ойлгуулахыг зорьсон нь сэдэв сонголтын хувьд оновчтой болсныг уг нээлтэд оролцсон оролцогчид хэлж байлаа. Хурандаа Ч.Баатар нь өнгөрсөн хугацаанд цэргийн эрдмийн чиглэлийн сурах бичиг, уран сайхны киноны зохиол, өөрийн амьдралын дурсамж, дурдатгалаараа олон шилдэг бүтээлийг төрүүлсэн нь олон мянган уншигчдын хүртээл болсон юм.

ЦАГ ҮЕ

ӨНӨӨДӨР АЖИЛЛАХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЦЭГҮҮД

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН 5 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

№	ДҮҮРГИЙН НЭР	БАГИЙН ТОО	АЖИЛЛАХ ХҮНИЙ ТОО	ХАМРАГДАХ ХҮНИЙ ТОО
1	БАГАНУУР	4	30	800
2	БАГАХАНГАЙ	1	6	220
3	БАЯНЗҮРХ	18	145	3710
4	БАЯНГОЛ	18	120	3250
5	СОНГИНОХАЙРХАН	18	129	3550
6	СҮХБААТАР	10	71	3250
7	НАЛАЙХ ДҮҮРЭГ	5	34	820
8	ЧИНГЭЛТЭЙ	21	78	3400
9	ХАН-УУЛ	15	105	3560
10	ЯВУУЛЫН АВТОБУС	1	4	50
11	ТӨВ ЭМНЭЛГҮҮД	6	45	200
НИЙТ		117	767	22860

АСТРАЗЕНЕКА ВАКЦИНЫ ДАВТАН, 55-ААС ДЭЭШ НАСНЫ ИРГЭЭД СПУТНИК V ВАКЦИН, ЭЛСЭЭТИЙН ШАЛГАЛТ ӨГӨХ 18-19 НАСНЫ ИРГЭЭД ВЕРОЦЕЛ ВАКЦИН ХИЙГЭЭНЭ

Зэвсэгт хүчний 186 дугаар анги



Зуны тэргүүн сарын шинийн 15-н буюу "Бурхан багшийн их дүйчэн" өдөр Архангай аймгийн Гандан Тэгчлэн хийдэд шавилан сууж,

ном хурж байсан Минометрын батареин байлдагч Н.Батмөнх хугацаат цэргийн алба хаагчдад зориулан хийморийн сан, цагаан дарь эх номыг хурлаа.

Мөн Соёл хүмүүжлийн албанаас санаачилсан мод тарих өдрөөр бие бүрэлдэхүүн 20 гаруй Улиас модыг ангийн байрлалд тарилаа.

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

Эхийг "Соёмбо" сонинны редакцид бэлтгэв.

*Зар, рекламныг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, ээхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонинны нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонинны мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029